

“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК

Огноо: **2019.03.06**

**ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭСГИЙН УРСГАЛ ЗАСВАРЫН МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕРИЙН УРИЛГЫН ДУГААР: ХӨАДСТӨХК/201901012

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭСГИЙН УРСГАЛ ЗАСВАРЫН МАТЕРИАЛ**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН 10 ЦАГ 00 МИНУТ**-аас өмнө **ХӨВСГӨЛ АЙМАГ МӨРӨН СУМ 8-Р БАГ СВ ТӨВИЙН БАЙР 4 ДАВХАР** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН 10 ЦАГ 10 МИНУТ**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх-ҮГҮЙ

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХӨВСГӨЛ АЙМАГ МӨРӨН СУМ 8-Р БАГ СВ ТӨВИЙН 4 ДАВХАР 401 ТООТ ӨРӨӨ
/цахимаар/

ХАРИЛЦАХ УТАС: 70388489, 88098503

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт</p> <p>Сүүлийн [1] жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <ol style="list-style-type: none"> 1. УБГ-ний эхээс хийсэн хуулбар 2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар 3. Шүүхийн тодорхойлолт 4. ШШГГ-ын тодорхойлолт 5. Татварын тодорхойлолт 6. Харилцагч банкны тодорхойлолт 7. Техникийн тодорхойлолт 8. Нийлүүлэгч байнгын борлуулалтын цэгтэй байх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Худалдан борлуулах</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, 8-р баг SB төвийн барилга 4 давхар 401 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: цахим</p> <p>Огноо: 2019 оны 03-дугаар сарын 15-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, 8-р баг SB төвийн барилга, 4 давхар 401 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: цахимаар</p> <p>Огноо: 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: байхгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Дулаан үйлдвэрлэлийн хэсгийн урсгал засварын материал
2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.*
3. **Баглаа, боодол:** захиалагч тухайн барааг худалдан авах тухай бүрт бүрэн бүтэн байдлыг шалгаж авна.
4. **Бараа хүргэх газар:** Нийлүүлэгчийн борлуулалтын цэг
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	<i>/барааны жагсаалтаар/</i>			<i>Нийлүүлэгчийн борлуулалтын цэг</i>	<i>Гэрээ байгуулсан даруй</i>	<i>2019.12.31</i>	

Батлав: Ерөнхий инженер

О.Төмөрхуяг

Дулаан үйлдвэрлэлийн хэсгийн Урсгал засвар, сэлбэг хэрэгслийн зардлын жагсаалт

№	Хийгдэх ажлууд	Х/Н	Тоо	Марк	Хийгдэх ажил
1	Транспораторын тос	л	20		УЗ, 100кВА-ын 2ш, 250 кВА, 100кВА, 63 кВА тус бүр 1ш нийт 5 трансформаторын тосыг жил бүр туршуулдаг. Үүнийг нөхөн дүүргэх.
	Лист 1мм	м2	10	1мм зузаантай стал-45	Үйлдвэрийн урсгал засварт
	Лист 2мм	м2	10	2мм зузаантай стал-45	Үйлдвэрийн урсгал засварт
	Лист 3мм	м2	10	3мм зузаантай стал-45	Үйлдвэрийн урсгал засварт
	Лист 4мм	м2	40	4мм зузаантай стал-45	Үйлдвэрийн урсгал засварт, ДДТ-дийн аваарын схем хийх
	Лист 5мм	ш	10	5мм зузаантай стал-45	Үйлдвэрийн урсгал засварт
	Цилкон	ш	50		Үйлдвэрийн урсгал засварт
	Катанг ф10	м	100	10мм диаметртэй	Үйлдвэрийн урсгал засварт
	Катанг ф6	м	50	ф6 диаметртэй	Үйлдвэрийн урсгал засварт
	Гууль ф 90	м	1	ф 90 диаметртэй	Үйлдвэрийн урсгал засварт
	Цул төмөр ф 60	м	6	ф 60 диаметртэй	Үйлдвэрийн урсгал засварт
	Хасуур	ш	4	Хэмжээ: 1"х12"	Үйлдвэрийн урсгал засварт
	Электрод ф3 /422/	кг	1150	ф3 /422/	Үйлдвэрийн урсгал засварт
	Электрод ф2 /422/	кг	500	ф2 /422/	Үйлдвэрийн урсгал засварт
	Электрод ф3 506/	кг	200	ф3 506/	Үйлдвэрийн урсгал засварт
	Ширэмний электрод	кг	10	3,2Х350мм	Үйлдвэрийн урсгал засварт
	Нерж электрод	кг	10	OK61.30, 1.6мм	Үйлдвэрийн урсгал засварт
	Хөнгөн цагааны электрод	кг	5	OK96.50 – 3.2мм	Үйлдвэрийн урсгал засварт
	Хуурайн набор	ком	2	бөөрөнхий, гурвалжин дөрвөлжин	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
	Боолт м16	ш	1370	м16	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт

Гайк м16	ш	1370	м16	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Шайб м16	ш	100	м16	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Боолт м18	ш	50	м18	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Гайк м18	ш	50	м18	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Боолт м10	ш	50	м10	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Боолт м22	ш	20	м22	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Боолт м21	ш	30	м21	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Гайк м21	ш	30	м21	Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Бусад боолт, гайк	ш	200		Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Бусад шайб	ш	100		Үйлдвэр, ДДТ-үүдийн урсгал засварт
Тайрагчийн ир ф180	ш	2100	ф180	Үйлдвэрийн урсгал засварт-2000, ДДТ-100 ширхэг
Тайрагчийн ир ф150	ш	1500	ф150	Үйлдвэрийн урсгал засварт
Тайрагчийн ир ф105	ш	1500	ф105	Үйлдвэрийн урсгал засварт

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019.03.15

Хөвсгөл Дулааны Станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Цогоо танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [заахгүй] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [30] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг магадлан комисс хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Доголдолтой барааг тухай бүрт солиж өгөх үүргийг гүйцэтгэгч хариуцана.</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн зохих хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0,5]</p> <p>Алдангийн нийт дүн: [10%]</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]